



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1 (382)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- *Зарим хүмүүст тэтгэлэг олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны нэгдүгээр сарын 7

№1 (382)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

487.	Даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2
488.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

489.	Хуулиудын төслийг буцаах тухай	Дугаар 38	2
490.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 39	2
491.	Тогтоолын төсөл буцаах тухай	Дугаар 40	3
492.	Зарим хүмүүст тэтгэлэг олгох тухай	Дугаар 41	3

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

493.	Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай	Дугаар 236	3
	-Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр		5
	-Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр		11
	-Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр		17



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн дугаар сарын 1-ний өдрөөс" гэж өөрчилсүгэй. 85.1-ийн "1 дүгээр сарын 1-ний өдрөөс" гэснийг "6

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2004 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.5-д дараахь заалт нэмсүгэй: 2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.1 дэх заалтын ", тамга, тэмдэг" гэснийг хассугай.

1/ "15.5.11. тамга, тэмдэг үйлдвэрлэх."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар хот

Хуулиудын төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулгааны хуралдааны дэгийн 23.3.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Чингис хаан" нэр, Чингис хааны хөргийг хэрэглэх асуудлыг хуульчлан зохицуулах зорилгоор боловсруулагдсан хуулиудын төсөл нь тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгаагүй гэж үзсэн тул

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн "Чингис хаан" нэр, Чингис хааны хөргийг хэрэглэх тухай, "Чингис хаан" нэр, Чингис хааны хөргийг ашигласны төлбөрийн тухай хуулиудын төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд түүхэн тэмдэглэлт өдрийг нэмж оруулахдаа цогц байдлаар авч үзэн тодорхой судалгааны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй байх тул Монгол Улсын

Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

Тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2004 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын

төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Зарим хүмүүст тэтгэлэг олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн эсан Ш.Батбаяр, Ж.Гуррагчаа, Б.Жигжид, Д.Насанжаргал, П.Нямдаваа, Л.Эрдэнэчулуун, Ч.Ганзориг нарт тодорхой ажил, албан тушаал

эрхлэх хүртэлх 6 сарын хугацаанд хууль тогтоомжоор тогтоосон цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэлэг олгохыг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2004 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 236

Улаанбаатар хот

Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр зөвшөөрөх, бүтэц батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 1 дүгээр авсралт ёсоор, Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 2 дугаар авсралт ёсоор, Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 3 дугаар авсралт ёсоор, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 4

дүгээр хавсралт ёсоор, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 5 дугаар хавсралт ёсоор, Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 6 дугаар хавсралт ёсоор, Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг 7 дугаар хавсралт ёсоор тус тус зөвшөөрсүгэй.

2. Дараахь яамдын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а/Хууль зүй, дотоод хэргийн яам:

1/Хууль зүйн бодлогын газар;

2/Зохицуулалт, мэдээлэл, хяналт-шинжилгээний газар /Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэстэй/;

3/Төрийн захиргааны удирдлагын газар /Төлөвлөлт, санхүүгийн хэлтэстэй/;

4/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс.

б/ Байгаль орчны яам:

1/Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газар;

2/Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны газар /Байгаль орчны мэдээлэл, сургалт, сурталчилгааны албатай/;

3/Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар;

4/Төрийн захиргааны удирдлагын газар;

5/Ойн бодлого зохицуулалтын хэлтэс;

6/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс;

7/Төсөв, санхүү, аж ахуйн хэлтэс.

в/Батлан хамгаалах яам:

1/Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны газар /Гадаад хамтын ажиллагааны хэлтэс, Улсын дайчилгааны хэлтэстэй/;

2/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Бодлого зохицуулалтын хэлтэс, Санхүүгийн хэлтэстэй/;

3/Төрийн захиргааны удирдлагын газар;

4/Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

г/Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам:

1/Боловсролын газар /Ерөнхий боловсролын хэлтэс, Мэргэжлийн боловсролын хэлтэстэй/;

2/Соёл, урлагийн газар;

3/Шинжлэх ухаан, технологийн газар;

4/Эдийн засаг, санхүүгийн газар;

5/Мэдээлэл, хяналт-шинжилгээний газар;

6/Төрийн захиргааны удирдлагын газар;

7/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс.

д/Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам:

1/Хүн амын хөгжлийн бодлого зохицуулалтын газар;

2/Нийгмийн хамгааллын бодлого зохицуулалтын газар;

3/Хөдөлмөрийн зах зээлийн бодлого зохицуулалтын газар;

4/Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;

5/Төрийн захиргааны удирдлагын газар;

6/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс;

7/Санхүү, эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс.

е/Үйлдвэр, худалдааны яам:

1/Нэгдсэн бодлого, стратеги төлөвлөлтийн газар;

2/Үйлдвэрийн бодлого зохицуулалтын газар /Жижиг, дунд үйлдвэр, технологийн хөгжлийн хэлтэстэй/;

3/Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого зохицуулалтын газар;

4/Геологи, уул уурхайн бодлого зохицуулалтын газар;

5/Төрийн захиргааны удирдлагын газар /Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Төсвийн удирдлага, санхүүжилтийн хэсэгтэй/.

ж/Эрүүл мэндийн яам:

1/Санхүү, эдийн засаг, удирдлага төлөвлөлтийн газар;

2/Эмнэлгийн тусламжийн газар;

3/Эрүүл мэндийн бодлого, зохицуулалтын газар /Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэстэй/;

4/Төрийн захиргааны удирдлагын газар;

5/Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;

6/Гадаад хамтын ажиллагааны хэлтэс.

3. Яамдын орон тооны хязгаар, зардлын төсвийн хязгаарыг дор дурдсанаар тогтоосугай:

Д/д	Яам	Орон тооны хязгаар	Урсгал зардлын төсвийн хязгаар /мян.төг/	Үүнээс цалингийн сан /мян.төг/
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	74	390989.1	96759.5
2	Байгаль орчны яам	50	236163.3	86459.0
3	Батлан хамгаалах яам	63	436805.7	121551.1
4	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	70	219290.0	98696.3
5	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	48	178304.2	64343.7
6	Үйлдвэр, худалдааны яам	68	373107.2	110415.5
7	Эрүүл мэндийн яам	73	355883.1	130478.1

4. Батлагдсан цалингийн сан, урсгал төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа явуулахыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Ерөнхий менежер нарт үүрэг болгосугай.

5. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төвийг байгуулж, уг төвийн бүтэц, дүрмийг батлан мөрдүүлэх арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн

сайд Т.Ганди, төсвийг хянаж өгөхийг Сангийн сайд Н.Алтанхуяг нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **С.БАЯРЦОГТ**

*Засгийн газрын 2004 оны 236 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт*

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-т Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд няалт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэх, сууль зүйн туслалцаа үзүүлэх, эрхийг нь баталгаажуулах үйлчилгээг нийт хүн амд үзүүлэх, улсын хил хамгаалалт, гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга эмжээ авах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой асуудлыг хамарсан Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын бүтцийн тухай хууль, Засгийн газрын тухай хууль, Яамны эрх зүйн байдлын тухай сууль, "Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Засгийн газрын тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, үүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн байгууллагын удирдлага, захиралын тухай хууль;

Төрийн албаны тухай хууль;
Яамны эрх зүйн байдлын тухай хууль;
Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлт зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Хууль зүй, дотоод хэргийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд хууль зүй, дотоод хэргийн хүрээнд үүрэг, хариуцлага хүлээж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын Танхимд дээр дурдсан хүрээнд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь эрх зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөлтийн болон бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцдог удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Хууль зүй, дотоод хэргийн яам нь Засгийн газрын хуулийн зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Хууль зүй, дотоод хэргийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг оновчтой, бүрэн тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарагдана:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын Танхим болно. Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Хууль зүй, дотоод хэргийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд яамны болон харьяа тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааг чиглүүлэх, эрх зүйн зөвлөлгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах замаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газар /Танхим/-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, сайн засаглал тогтооход дэмжлэг үзүүлэх;

2.2.2. Яамны хэмжээнд удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, иргэн, байгууллагад үзүүлэх хууль зүйн үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх;

2.2.3. Хууль зүй, дотоод хэргийн яамны өөрчлөлт, хөгжлийн стратегитэй уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар яамны аппаратыг цомхон, чадварлаг болгон өөрчлөн хөгжүүлэх, өртөг, зардлыг бууруулахад чиглэсэн нийтлэг үйлчилгээг бий болгон хөгжүүлэх;

2.2.4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлагаас үзүүлэх төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх;

2.2.5. Гадаад орны ижил төрлийн байгууллагуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний хэрэгжилтийг сайжруулах.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд Үндсэн хуулиар тогтоосон эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэх, үүргээ биелүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх явдал мөн.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Хууль зүй, дотоод хэргийн яам нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараахь стратегийн зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ:

2.4.1. Эрх зүйн шинэтгэл, хууль зүйн бодлогын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.4.2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.4.3. Эрх зүйн шинэтгэлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг зохицуулах, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны бодлого боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.4.4. Яам, агентлаг, хууль сахиулах байгууллагуудын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Эрх зүйн шинэтгэлийн стратегийг төлөвлөх;

2.5.1.2. Үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох;

2.5.1.3. Эрх зүйн шинэтгэлийн бодлогын удирдамжаар хангах;

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох;

2.5.2.2. Сайдаас шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх;

2.5.2.3. Яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох;

2.5.2.4. Эрх зүйн албан сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, бодлогын удирдлагаар хангах;

2.5.2.5. Хуульчдын сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг эрхлэн түүнийг боловсронгуй болгох.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Эрх зүйн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/, үнэлгээ хийж уялдуулах;

2.5.3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийж, үнэлгээ өгөх;

2.5.3.3. Агентлагийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, түүнд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийж, үнэлгээ өгөх;

2.5.3.4. Шүүх, прокурор, өмгөөлөх, нотариат, орон нутгийн хууль зүйн албадын харилцан ажиллагааг хангах;

2.5.3.5. Хуульд тусгайлан заасан улсын нэгдсэн бүртгэл, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг эрхлэх;

2.5.3.6. Эрх зүйн үйлчилгээний үр нөлөөнд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх;

2.5.3.7. Эрх зүйн албан бус сургалтын болон хууль тогтоомжийн мэдээлэл, сурталчилгааны бодлого боловсруулах, хэрэгжилтийг хянах.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. Хуулийн салбарт үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагатай харилцаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

2.5.4.2. Хүний эрхийн олон улсын конвенциуд, эрх зүйн тусалцаа харилцан үзүүлэх тухай гэрээний хэрэгжилт, гадаад орны шүүх, арбитрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах;

2.5.4.3. Олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, санал боловсруулах;

2.5.4.4. Гадаадын зээл, буцалтгүй тусламж, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах.

тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.


2.6. Үйл ажиллагааны зорилт

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА /БИЗНЕС/-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР





3. Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараахь зарчмыг баримтлав:

3.1.1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим;

3.1.2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим;

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим;

3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим;

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим;

3.1.6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим;

3.1.7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим.

3.2. Зохион байгуулалтын бүтэц

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

1. Эрх зүйн шинэтгэлийн стратегийн удирдлага, нэгдсэн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний эрх зүйн

шинэтгэлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, Монгол Улс дахь хууль зүйн бодлогын стратегийг төлөвлөх, үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, эрх зүйн шинэтгэлийн бодлогын удирдамжаар хангахад мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, Хууль зүй, дотоод хэргийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газар /Танхим/ байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Улсын Их Хурал, бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, ашгийн төлөө хуулийн этгээд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга барилыг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог бэхжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ. Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдаас шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон бусад үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай

мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжийн бүтцэд яамны аж ахуй, үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагаа хамаарна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам болон боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

3. Эрх зүйн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, хэрэгжилтийг зохицуулах, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд эрх зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч зохицуулах, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих, түүнчлэн эрх зүйн албан бус сургалтын болон хууль тогтоомжийн мэдээлэл, сурталчилгааны бодлого боловсруулж хэрэгжилтийг хянах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Энэ нэгжийн үйл ажиллагааны нэг гол үүрэг нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ. Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварт хяналт-шинжилгээ хийж, яамны бүтцийн

нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газар /Танхим/, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, шүүх, прокурор, өмгөөлөх, нотариат, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус болон шашны байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний болон хэвлэл мэдээллийн байгууллага байна.

4. Гадаад хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд яам, агентлаг, хууль сахиулах байгууллагуудын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь гадаадын зээл, буцалтгүй тусламж, төслийг хэрэгжүүлэх хүрээнд техникийн тусалцаа авах, бусад орны туршлагыг судлах ажлыг зохицуулахад чиглэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд байх бөгөөд шууд бус хэлбэрээр Улсын Их Хурал, бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, Элчин сайдын яамд, олон улсын байгууллага, нутгийн өөрөө удирдах болон хууль сахиулах байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

• Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал;

1.1. Оршил

• Төрөөс экологийн талаар баримтлах бодлого;

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/т Байгаль орчны сайдын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

• Бусад хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт бичиг.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, байгууллагын өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлтийн арга зүйг хэрэглэв.

1.2. Үндэслэл

1.5. Чиглэлийн яамны үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын тухай хуулийг үндэслэн боловсруулав.

Чиглэлийн яамдын нэг болох Байгаль орчны яам нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээж, Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

Байгаль орчны яам нь стратегийн бодлого, төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилт болон салбарын төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ. Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлийн яамдын нэг Байгаль орчны яам нь Засгийн газрын байгаль орчны зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

• Монгол Улсын Үндсэн хууль;

• Засгийн газрын тухай хууль;

• Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;

• Төрийн албаны тухай хууль;

• Байгаль орчныг хамгаалах тухай хууль;

• Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;

1.6. Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дараахь загварт харуулсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Байгаль орчны яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхим байна.

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, зааг хүрээг тодотгож төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Байгаль орчны сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Байгаль орчны яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн экологийн бодлого, стратегийг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх;

2.2.2. Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, өөрийн харьяа байгууллага, чиглэлийн яам, аж ахуйн нэгж, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан зохицуулах;

2.2.3. Байгаль орчны яамыг төрийн албыг мэргэжлийн өндөр түвшинд явуулах чадвар бүхий цомхон байгууллага болгох;

2.2.4. Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг ажиглан шинжлэх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэж буй арга механизм, нөөц баялгийн зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийн бодлого, чиглэл экологийн тэнцлийг хангах шаардлагад хэрхэн нийцэж байгаа талаас нь үнэлж цэгнэж стратеги төлөвлөгт, бодлогын удирдамжаар хангах ажлын арга, технологийг сайжруулах.



2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Байгаль орчны яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгод нийцүүлэн экологийн тэнцлийг хангаж тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэх явдал мөн.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Байгаль орчны яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Байгаль орчны стратеги төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2.4.2. Хүрээлэн буй орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг бууруулах, орчны бохирдол, доройтлыг багасгахад чиглэсэн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны удирдамжаар хангах;

2.4.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, зохицуулалтаар хангах;

2.4.4. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

2.4.5. Ойн бодлого зохицуулалтаар хангах;

2.4.6. Байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Байгаль орчны яамны үйл ажиллагааны хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үзэл баримтлал, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;

2.5.1.2. Байгаль орчны стратеги төлөвлөлтийн чанар, хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах;

2.5.1.3. Байгаль орчныг хамгаалах, орчны доройтлыг бууруулах хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, төсвийн төслийг төлөвлөх, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдан зохицуулах.

2.5.2. Үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Байгаль орчны тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах арга хэмжээний төсөл, санал боловсруулах;

2.5.2.2. Аливаа төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөлд авсан газар нутгийг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулах;

2.5.2.3. Байгаль орчны төлөв байдалд үнэлгээ дүгнэлт өгөх, мэдээллийн сан бүрдүүлж мэдээллээр хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах, орчны бүс нутаг, аялал жуулчлалыг хөгжүүлэх.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. Байгаль орчны удирдлагын чадавхийг сайжруулах;

2.5.4.2. Байгаль орчны салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

2.5.4.3. Байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох.

2.5.5. Үйл ажиллагааны стратегийн тавдугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1. Ойн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохижтой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх арга хэмжээг зохион байгуулах.

2.5.6. Үйл ажиллагааны стратегийн зургадугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1. Байгаль орчны хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны бодлого, чиглэл боловсруулж хэрэгжүүлэх, уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Байгаль орчны яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Байгаль орчны яамны үйл ажиллагаа / бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

Үйл ажиллагааны стратегийн чиглэл

Эрхэм зорилго
Үйл ажиллагааны стратегийн зорилт
Үйл ажиллагааны гол зорилт

Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгод нийцүүлэн экологийн тэнцлийг хангаж тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэх

1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

2. Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах

3. Хүрээлэн буй орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг бууруулах, орчны бохирдол, доройтлыг багасгахад чиглэсэн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны удирдамжаар хангах

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтаар хангах

5. Ойн бодлого зохицуулалтаар хангах

6. Байгаль орчны гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх

Байгаль орчны удирдлагын чадавхийг сайжруулах

Байгаль орчны салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх

Байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох

Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн экологийн тэнцвэрт байдлыг хадгалах үзэл баримтлал, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх

Байгаль орчны стратеги төлөвлөлтийн чанар, хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах.

Байгаль орчныг хамгаалах, орчны доройтлыг бууруулах хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, төслийн төслийг төлөвлөх, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг удирдан зохицуулах ;

Байгаль орчны төлөв байданд үнэлгээ дүнэлт өгөх, мэдээллийн сан бүрдүүлж мэдээллээр хангах, хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа явуулах

Аливаа төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөлөөлд авсан газар нутгийг нөхөн сэргээх

Байгаль орчны тогтвортой хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах арга хэмжээний төсөл, санал боловсруулах

Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохицуулах, орчны бүс нутаг, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойн хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, ойн хөдөөт шалыгтай тэмцэх

Хамтын ажиллагааг хөгжүүлж, бодлого, чиглэл боловсруулж, хэрэгжүүлэх

Олон улсын төслийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх, зохицуулалтыг сайжруулах



3. Байгаль орчны яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Байгаль орчны яам нь үйл ажиллагааныхаа бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэцэд дор дурдсан зарчмыг баримтална:

3.1.1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй уялдуулан тус яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим;

3.1.2. Эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл жүлээхүйц байх зарчим;

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим;

3.1.4. Бүтцийн хувьд энгийн, ойлгомжтой байх зарчим;

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтооход дөхөмтэй байх зарчим;

3.1.6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим;

3.1.7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

Байгаль орчны яамны үйл ажиллагааны ерөнхий загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүргийг тодорхойлж байна:

3.3.1. Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион

байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн үүргийг хүлээж, байгаль орчны стратегийн төлөвлөлтийг сайжруулах, орчны доройтлыг бууруулж нөхөн сэргээх ажлын бодлогыг тодорхойлох, байгаль орчны болон олон улсын

хамтын ажиллагааг бодлогын удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг төлөвшүүлж хэрэгжүүлэх, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Байгаль орчны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Байгаль орчны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, байгаль орчны бодлого, байгалийн нөөцийн болон экологийн тэнцвэрт байдлыг хангах үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдыг шаардлагатай мэдээлэх, өндөр мэргэжлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, бусад төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бүх шатны Засаг дарга нар, тэдгээрийн Тамгын газар байна.

3.3.2. Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд байгаль орчны бодлогын хэрэгжилт, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт шөвчилгээ/мониторинг/ хийх, үр дүнд үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, байгаль орчинд нөгөөлөх байдлын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, байгаль орчны мэдээллийн санг брдүүлэх, дотоод сүлжээ байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнд дээшлүүлэхэд чиглэнэ. Үүнийг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварт хяналт тавих замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжилтэд оролцож байгаа бүх байгууллага, удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага зэрэг бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам, нутгийн захиргааны байгууллага байна. Энэ нэгжийн бүтэцэд Байгаль орчны мэдээлэл, сургалт сурталчилгааны асуудал эрхэлсэн алба ажиллана.

3.3.3. Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд тусгай хамгаалалттай газар нутгийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах, түүний сүлжээг өргөжүүлэх, хамгаалалтын захиргаадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгаль орчны бодлого, байгалийн нөөцийн болон экологийн тэнцэлт байдлыг хангах үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэнэ. Энэ нь нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага зэрэг бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Зам, тээвэр, аялал жуулчлалын яам, нутгийн захиргааны байгууллага байна.

3.3.4. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж хүний нөөцийн удирдлага хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, ажлаа тайлагнах, харьцуулаа тооцох тогтолцоог хөгжүүлэх, өргөдөл, гомдлыг барагдуулах, байгууллагын удирдлагыг боловсронгуй болгох зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.



Энэ нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн, цомхон албаны хүчээр яамны гасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангах бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь нутгийн захиргааны байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна. Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Төрийн албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар байна.

3.3.5. Ойн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн тавдугаар зорилтын хүрээнд ойн талаархи үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, ойг хамгаалах, нөхөн сэргээж, зохистой ашиглах бодлогыг хэрэгжүүлэх, зохион байгуулах, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх үндсэн үүргийг хүлээж, бодлого зохицуулалтыг сайжруулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгаль орчны бодлого, байгалийн нөөцийн болон экологийн тэнцвэрт байдлыг хангах үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэнэ. Энэ нь нөөцийг оновчтой хуваарилгах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага зэрэг бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Үйлдвэр, худалдааны яам, нутгийн захиргааны байгууллага байна.

3.3.6. Хамтын ажиллагаа эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн зургадугаар зорилтын хүрээнд байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулалт хийх, олон улсын төсөл боловсруулан санхүүгийн гадаад эх үүсвэр олж хэрэгжилтийг хангах, манай улсаас байгаль орчны салбарт нэгдсэн конвенци, гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг биелүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь байгаль орчны салбарын олон улсын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь олон улсын байгууллагууд, гадаад орнууд, олон улсын төслийг хэрэгжүүлэхэд оролцогчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад хэргийн яам, Сангийн яам байна.

3.3.7. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөлт, тайлагнал, хяналтын болон яамны үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах чиг үүргийг хариуцсан нэгжтэй байж болно.

Засгийн газрын 2004 оны 236 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1. Нийтлэг үндэслэл

1.1. Оршил.

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэх/-т Засгийн газрын Танхимын болон Батлан хамгаалахын сайдын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага,

зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлох.

1.2. Үндэслэл.

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт

бичиг, Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төрийн цэргийн бодлогын үндэс;
- Засгийн газрын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль;
- Яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Батлан хамгаалах тухай хууль;
- Зэвсэгт хүчний тухай хууль;
- Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль;
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Дайчилгааны тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй.

Хөтөлбөрийг боловсруулахад төрийн захиргааны байгуулалтын онол, арга зүйд

тулгуурлан, батлан хамгаалах салбарын енөөгийн байдалд орчны шинжилгээ хийж, олон улсын туршлагыг судалж, нэгтгэн дүгнээд үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн менежментийн аргыг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Батлан хамгаалах яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимд мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Батлан хамгаалах яам нь улс орныг батлан хамгаалах стратегийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалт болон салбарын төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудлыг зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Батлан хамгаалах яам нь Засгийн газрын батлан хамгаалахын зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарана:

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Батлан хамгаалах яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхим байна.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох явдал тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2. Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Батлан хамгаалахын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Батлан хамгаалах яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. Батлан хамгаалах яамыг улс орныг батлан хамгаалах стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөржүүлэх, зохицуулах, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиг үүрэгтэй төрийн захиргааны төв байгууллага болгох замаар үйл ажиллагааныг нь үр дүнг дээшлүүлэх;

2.2.2. Зах зээлийн эдийн засгийн харилцааны онцлогт нийцсэн, орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх;

2.2.3. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэн төрөөс зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.2.4. Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, тайван цагийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадвар бүхий анги, салбаруудын тоо, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох чадварийг нэмэгдүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, чадварлаг болгох үндсэн дээр улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хүний аюулгүй байдлыг найдвартай хангах явдал мөн.

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Батлан хамгаалах яам нь эрхэм зорилгоныхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1. Батлан хамгаалах хууль тогтоомжийн төсөл, бодлого, үйл ажиллагааны урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, иргэний хамгаалалтын бодлого, батлан хамгаалах гадаад харилцааны бодлого, улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах;

2.4.2. Төрийн захиргааны манлайлал, хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, батлан хамгаалах үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах, яамны нээлттэй байдлыг хангах;

2.4.3. Батлан хамгаалах бодлогын болон төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

2.4.4. Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилт, батлан хамгаалах

төсвийн бодлого, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг дэвшүүлэн ажиллана:

2.5.1. Үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1. Улс орныг батлан хамгаалах эрх зүйн үндсийг боловсронгуй болгоход оролцож, батлан хамгаалах салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, гадаад харилцаа, цэргийн шинжлэх ухаан, технологи, батлан хамгаалах эдийн засаг, төсвийн бодлого болон тэдгээрийн хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах;

2.5.1.2. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн хэрэгжилтийг бодлогын удирдамжаар хангах, цэргийн гадаад харилцааны чиглэлээр мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;

2.5.1.3. Улсын дайчилгааны болон улс орныг дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг хангах, төлөвлөлт, дайчилгааны даалгаврыг боловсруулах, тодотгох, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын дайчилгааны төлөвлөлтийг боловсруулах, тодотгох, орон нутгийн хамгаалалтын үндсийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.5.1.4. Үй элнээр хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах бодлого, урт болон дунд хугацааны төлөвлөлтийг боловсруулах, нутгийн захиргааны байгууллагууд дахь цэргийн штабын үйл ажиллагаанд мэргэжлийн удирдлага, дэмжлэг үзүүлэх.

2.5.2. Үйл ажиллагааны хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах

2.5.2.2. Хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;

2.5.2.3. Батлан хамгаалах бодлогыг сурталчлах, яамны нээлттэй байдлыг хангах, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх.

2.5.3. Үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1. Батлан хамгаалах бодлогын хэрэгжилт, зэвсэглэл, техник, материал хэрэгслийн хангалтын хөтөлбөрийг зохицуулах, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх;

2.5.3.2. Батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг боловсруулах, зохицуулалт хийх, хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх.

2.5.4. Үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1. Батлан хамгаалах хууль тогтоомж, үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтийг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, холбогдох агентлаг, харьяа байгууллагад танилцах, хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;

2.5.4.2. Батлан хамгаалах төсвийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх;


2.5.4.3. Батлан хамгаалах салбарт мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн компьютерт суурилсан удирдлагын автоматжуулсан сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан байгуулах төсөл, хөтөлбөрийг удирдлагаар хангах.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:



3. Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож байгаа зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим;

3.1.2. Эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим;

3.1.3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим;

3.1.4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим;

3.1.5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим;

3.1.6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим;

3.1.7. Хангалттай чадавхи, бэдитой үйл ажиллагааны зарчим.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтэц

3.3.1. Бодлого, төлөвлөлт, гадаад хамтын ажиллагаа эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд батлан хамгаалах үйл ажиллагааны эрх зүйн орчинг боловсронгуй болгох,

улс орныг батлан хамгаалах үйл ажиллагааны урт, дунд, богино хугацааны болон салбарын гадаад хамтын ажиллагааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай болгон хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах, цэргийн шинжлэх ухаан, технологийн бодлого, хөтөлбөр, төсөл, улсын дайчилгааны

төлөвлөгөө, даалгавар, үй олноор хөнөөх зэвсэг болон хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах бодлого, урт болон дунд хугацааны төлөвлөлтийг боловсруулах, нутгийн захиргааны байгууллагууд дахь цэргийн штабын үйл ажиллагаанд мэргэжлийн удирдлага, дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх зэрэг чиг үүргийг хүлээнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Ерөнхийлөгч-Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага дахь батлан хамгаалах асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан, эрдэм шинжилгээ, судалгаа, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байна.

3.3.2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үндсэн үүрэг хүлээж, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, мэдээлэл, соёл, хэвлэл

сурталчилгааны ажлыг зохион байгуулах, иргэд, цэргийн албан хаагчийн өргөдөл, гомдлыг барагдуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн цомхон албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Батлан хамгаалахын сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэхэд туслах, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, цэргийн анги, байгууллагууд, нутгийн захиргааны байгууллага, төрийн холбогдох бусад байгууллага, иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байх болно.

3.3.3. Батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд батлан хамгаалах салбарын стратеги, эдийн засгийн болон төсөв, хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүрэг хүлээж, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагуудын зэвсэглэл, техник, материал хэрэгслийн хангалтын бодлогын

хэрэгжилтийг зохицуулах, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Батлан хамгаалахын сайдад мэргэжлийн зөвлөлгөө өгөх замаар батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, батлан хамгаалах бодлого ба зэвсэглэл, техник, материал хэрэгслийн нөөц, төсвийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэнэ.

Энэ нь нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын холбогдох тохируулагч агентлаг, яамны харьяа байгууллагууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, цэргийн анги, байгууллага, төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн нэгж, иргэд байх болно. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, бусад холбогдох яамд, Төрийн өмчийн хороо байна.

3.3.4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд хууль тогтоомж, батлан хамгаалах бодлогын хэрэгжилт, төсөв, эдийн засаг, санхүүгийн үйл ажиллагаа, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага,

батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагуудад танилцах, хяналт-шинжилгээ/мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, батлан хамгаалах салбарт мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, компьютерт суурилсан удирдлагын сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан байгуулах бодлогыг тодорхойлж, үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь батлан хамгаалах бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, яамны үйл ажиллагаанд төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах ажлын үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, алдаа дутагдлыг арилгуулах, түүнчлэн яамны үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, ажилтнуудыг сургаж дадлагажуулах болон техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, ашиглалтыг сайжруулахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, дэд сайд, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь цэргийн анги, байгууллага, бусад хэрэглэгчид байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлаг, эрдэм шинжилгээний болон аудитын байгууллага, тооцоолох төвүүд байна.

(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)